

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ГУРАВ ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 11 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөлд болон холбогдох хавсралтуудад тусгаж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд:

1.Төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн тэнцлийг сайжруулахтай холбоотой төсвийн орлогыг **127.7 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.Төрийн хэмнэлтийн тухай хууль болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зарим шаардлагагүй төсөл хөтөлбөр, урсгал зардлыг хэмнэж, төсвийн зардлыг **176.9 тэрбум төгрөгөөр** бууруулах;

3.Зарим шаардлагагүй зардлыг бууруулсан эх үүсвэрээр зохицуулалт хийн хүн ам ихтэй хот, суурингийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын

хөнгөлөлт олгох, хавдраас урьдчилан сэргийлэх үндэсний арга хэмжээ болсон “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойн хортон шавжтай тэмцэх, ой хамгаалах, хүүхэд хамгаалах арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэх, “хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилтуудыг бодитой ажил болгох зэрэг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд **176.9 тэрбум төгрөгөөр** төсвийн зардлыг тус тус нэмэгдүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг **19 их наяд 049.6 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **34.9 хувь**, нийт зарлагыг **20 их наяд 475.3 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **37.6 хувь**, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг **1 их наяд 425.7 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **2.6 хувьтай** тэнцүү байхаар тооцлоо. Тодруулбал, Засгийн газрын өргөн мэдүүлсэн нийт тэнцвэржүүлсэн орлогыг **127.7 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлж, төсвийн алдагдлыг **127.7 тэрбум төгрөгөөр** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **0.23 хувиар** сайжрууллаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын хэмжээг нэмэгдүүлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.


Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт, тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх тус Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн, төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН